



УЛААНБААТАР ХОТЫН
ЕРӨНХИЙ МЕНЕЖЕРИЙН
ТУШААЛ

2019 оны 07 сарын 02 өдөр

Дугаар А/190.

Улаанбаатар хот

Хот тохижилтын газарт тусгай зориулалтын
машин техник хүлээж авах
ажлын хэсэг байгуулах тухай

Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3, дахь заалт, Нийслэлийн Засаг даргын 2014 оны А/279 дүгээр захирамжаар батлагдсан "Захирамжлалын баримт бичиг боловсруулах, батлах, хянах, мэдээлэх журам"-ын 2 дугаар хэсгийн 2.4.1 дэх заалт, Нийслэлийн засаг даргын 2019 оны эрх шилжүүлэх тухай А/290 дүгээр захирамж, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны дүрмийн 2 дугаар хэсгийн 2.9.5, 3 дугаар хэсгийн 3.1.21 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн Засаг даргын 2019 оны А/290 дүгээр захирамжаар худалдан авсан хот тохижилтын тусгай зориулалтын машин, механизмыг хүлээн авч, ашиглалтад оруулах Ажлын хэсгийг хавсралт ёсоор байгуулсугай.


2. Хот тохижилтын тусгай зориулалтын машин, механизмыг нийлүүлэгч компаниас гэрээнд заасан техникийн үзүүлэлт, шаардлагын дагуу хянаж, актаар баталгаажуулан хүлээн авахыг Ажлын хэсэг /Г.Ууганбаяр/-т даалгасугай.

3. Актаар баталгаажиж хүлээн авсан машин, механизмыг нийслэлийн өмчид бүртгүүлэх ажлыг зохион байгуулах, нийлүүлэгч компанитай баталгаат засварын гэрээ байгуулж ажиллахыг Хот тохижилтын газар ОНӨААТҮГ /Б.Бямбадорж/-т үүрэг болгосугай.

УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР
БӨГӨӨД ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ
ДАРГА  С.ГАНТӨМӨР



Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн
2019 оны 07 сарын 08 өдрийн
#1909/2019 тушаалын хавсралт



АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн дарга:	Г.Ууганбаяр	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Тохижилт, хог хаягдлын удирдлагын хэлтсийн дарга
Гишүүд	С.Аригуун	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Тохижилт, хог хаягдлын удирдлагын хэлтсийн Ахлах мэргэжилтэн
	Р.Чойжилжав	Аудит, дотоод хяналтын хэлтсийн мэргэжилтэн
	Н.Болормаа	Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын Өмчийн төлөөлөл, менежментийн хэлтсийн мэргэжилтэн
	С.Батболд	Хот тохижилтын газар ОНӨААТҮГ-н Ерөнхий инженер
	Г.Эрдэнэбаатар	Хот тохижилтын газар ОНӨААТҮГ-н Авто баазын ерөнхий инженер
	А.Гантулга	Хот тохижилтын газар ОНӨААТҮГ-н Автобаазын ашиглалтын инженер
Нарийн бичгийн дарга	С.Мөнхбат	Хот тохижилтын газар ОНӨААТҮГ-н Санхүү бүртгэлийн хэлтсийн Ахлах нягтлан бодогч